



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/316

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны III/04 дүгээр тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.4.1, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Шинэ багш" хөтөлбөрийн хүрээнд багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, тогтвор суурьшилтай ажиллуулах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны газрын харьяа багш нарын орон сууцны барилгын ажилд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Багш нарын орон сууцны барилгын ажилд дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийг "Шинэ багш" хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

